



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/107/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024

Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор:

Б.Азбаяр

Утас: 99061429

Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
	Төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт дутуу бүрдсэн шалгаан нь 2018 оноос бүх тендерийг цахимаар зарласантай хобоотой байна.	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.25 № 2/19
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

E:\ajil\2019 on\STA 2018\1.Oron nutgiin umchiin gazar\4.Tailagnal\Аудитын гэрчилгээ.docx 2519003

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red square official stamp with Mongolian text is centered. A handwritten signature in black ink is written over the stamp, extending to the right.

Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн захирагч Ц.Идэрмөнх-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.25-наас 2019.02.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б. Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Орон нутгийн төсөвт байгууллагууд болон Төрийн өмчийн оролцоотой ОНӨҮГ-ын өмч, хөрөнгийн харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд зохицуулах мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоог олон улсын стандартад хүргэж, бүх шатны төсвийн хөрөнгийн зарцуулалтад хэмнэлт, үр ашиг, ил тод байдал, харилцан тайлагнах болон хариуцлагын зарчмуудыг баталгаажуулж, авилгал гарах нөхцлийг бууруулах, дотоодын үйлдвэрлэгч, гүйцэтгэгчийг дэмжих шударга өрсөлдөөнийг өрнүүлэх нөхцлийг бүрдүүлэх замаар эдийн засгийн хөгжлийг хурдасгахад дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутгийн өмч хөрөнгийг хамгаалах, шилжүүлэх, актлах гэх мэт харилцааг зохицуулах мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.5-д болон 48.3-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн захиалгыг үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах эрх олгох үйл ажиллагааг энэхүү хууль, журмын хүрээнд зохион байгуулах.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- ТБОНӨБАҮХАТ хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад

дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 2 хувиар сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгосон ба аккрузль сууриар бэлтгэгдсэн санхүүгийн тайлангийн хувьд дээрх үзүүлэлтийг суурь болгож авах нь зүйтэй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны Нийт зардал 1933734.0 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 38674.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшин дунд байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэв.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөг)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	11.4	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	2.6	
3	Албан шаардлага өгсөн	0	0.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	
	Дүн	2	14.0	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

2.8.1. Аймгийн ИТХ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй Toyota crown маркын 44-26 БНХ улсын дугаартай автомашиныг дуудлага худалдаагаар иргэн Ч.Алтангэрэл 3.0 сая төгрөгөөр худалдан авахаар ялсан бөгөөд дэнчингийн 450.0 мянган төгрөгийг тушааж үлдэгдэл 2550.0 мянган төгрөгийг тушаагаагүй байхад авлагаар тусгаагүй байна.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулав.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 132245.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 130884.1 мянган төгрөг буюу 98,9 хувьтай байна. Тайлант хугацаанд 1.3 сая төгрөг хэмнэгдсэн бөгөөд үүний 0.7 сая төгрөг нь цалийнгийн зардлаас, 0.4 сая төгрөг нь ажил олгогчийн НДШ, 0.2 сая төгрөг нь бусдаар гүйцэтгүүлэх ажил үйчилгээний зардлаас хэмнэгдсэн байна.

Төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт дутуу бүрдсэн шалгаан нь 2018 оноос бүх тендерийг цахимаар зарласантай хобоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу тогтоосон хугацаанд мэдээлбэл зохих 25 мэдээг хугацаандаа бүрэн, 7 хоногийн дотор мэдээлбэл зохих 460.9 сая төгрөгийн 32 гүйлгээгнээс 110.3 сая төгрөгийн 17 мэдээг цахим сайтад хугацаанд нь бүрэн байршуулж, 350.6 сая төгрөгийн 15 гүйлгээг хугацаанд нь байршуулаагүй байсныг Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар албан шаардлага өгсөн.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.1.1 Илрүүлэлт:

Өөрийн орлогыг ангилал тус бүрээр нь салгаагүйгээс дуудлага худалааны орлогоос 8.7 сая төгрөгийг өөрийн орлогоор бүртгэж зарцуулсан.

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 22.1-д заасан "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана" тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зарцуулсан

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төвлөрүүлэх орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг ангилал тус бүрээр нь батлуулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Саналгүй

3.2 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

3.2.1 Илрүүлэлт:

Дуудлага худалдааны хураамжийн орлого 2720.0 мянган төгрөгийг бэлнээр авч зарцуулсан.

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам" -ын 2.6--д заасан " Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кастаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Тайлант хугацаанд бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламжийг нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлд бүрэн тусгаагүй нуун дарагдуулсан байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Дуудлага худалдааны хураамжийг зарцуулахдаа Мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Саналгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019.05.25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3784479.37</u>	<u>7410149.00</u>
33	АВЛАГА	236580.37	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	236580.37	
35	БАРАА МАТЕРИАЛ	3547899.00	7410149.00
354	Хангамжийн материал	3547899.00	7410149.00
35410	Бичиг хэргийн материал	530999.00	605999.00
35420	Аж ахуйн материал	3016900.00	3264900.00
35430	Сэлбэг хэрэгсэл		2660000.00
35440	Түлш, шатах тослох материал		879250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8046398871.77</u>	<u>11422808573.12</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8046398871.77	11422808573.12
392	Биет хөрөнгө	8046398871.77	11422808573.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	1836671769.03	11101428252.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	-328694727.68	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	763812390.06	740812390.06
39204	Хуримтлагдсан элэгдэл	-378664528.36	-487119371.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25340871.60	26922771.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-17703974.49	-20668651.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13502970.00	13502970.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6096965.15	-7103145.11
39214	Бусад үндсэн хөрөнгө	8115198498.65	61321341.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1977285731.89	-6606284.99
39217	Ном	318300.00	318300.00
39301	Програм хангамж	450000.00	450000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450000.00	-450000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8050183351.14</u>	<u>11430218722.12</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>55244.00</u>	<u>0.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	55244.00	0.00
413	Өглөг	55244.00	0.00
4136	Бусад өглөг	55244.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	55244.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8050128107.14</u>	<u>11430218722.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8050128107.14	11430218722.12
512	Хуримтлагдсан үр дүн	8050128107.14	6330294631.64
51210	Өмнөх үеийн үр дүн	8050128107.14	8050128107.14
51220	Тайлант үеийн үр дүн		-1719833475.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		5099924090.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>8050183351.14</u>	<u>11430218722.12</u>

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	302603107.00	213900494.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21594000.00	103960290.00
120	Нийтлэг татварын бус орлого	21594000.00	103960290.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21594000.00	103960290.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20552240.00	101655890.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	617760.00	62400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	424000.00	2242000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	281009107.00	109940204.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	133484893.00	0.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	133484893.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	121035100.00	107245400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	121035100.00	107245400.00
1330	Төсвийн захирагчдаас	23600000.00	0.00
133003	Хөрөнгийн	23600000.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2889114.00	2694804.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2889114.00	2694804.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	797644860.82	734280176.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	797644860.82	734280176.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	655642166.82	653568201.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	92375732.00	97062802.00
210101	Үндсэн цалин	89108732.00	97062802.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3267000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10159556.63	11801547.75
210201	Тэтгэврийн даатгал	7589596.73	7987898.75
210202	Тэтгэмжийн даатгал	2569959.90	993191.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		784953.00
210204	Ажилгүйдлийн даатгал		182837.00
210205	Эрүүл мэндийн даатгал		1852668.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1185000.00	0.00
210304	Байрны түрээс	1185000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	7319450.00	8372231.00
210401	Бичиг хэрэг	2701850.00	3633700.00
210402	Тээвэр, шатахуун	3651600.00	3652550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	966000.00	1085981.00
2105	Нормативт зардал	300000.00	0.00
210502	Хоол, хүнс	300000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3230500.00	0.00
210604	Урсгал засвар	3230500.00	
2107	Томилолт, зочны зардал	4566800.00	4109500.00
210702	Дотоод албан томилолт	4566800.00	4109500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3102399.00	5579625.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2608919.00	5146200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80000.00	158400.00
210803	Даатгалын үйлчилгээ	262000.00	113005.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141480.00	140020.00

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10000.00	22000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	533402729.19	526642495.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5666300.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1000000.00	1000000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	526736429.19	525642495.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	142002694.00	80711974.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	8514114.00	2694804.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2889114.00	2694804.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5625000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3687.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3687.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	133484893.00	78017090.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	133484893.00	78017090.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	80.62
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		80.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-495041753.82	-520379682.13
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5836255.33	1199453793.37
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	5836255.33	235582383.91
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		963871409.46
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5836255.33	-1199453793.37
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-500878009.15	-1719833475.50

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	278579107.00	211596094.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21170000.00	101655890.00
120	Нийтлэг татварын бус орлого	21170000.00	101655890.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21170000.00	101655890.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20552240.00	101655890.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	617760.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	257409107.00	109940204.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	133484893.00	0.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	133484893.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	121035100.00	107245400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	121035100.00	107245400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2889114.00	2694804.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2889114.00	2694804.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	278579107.00	211256194.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	278579107.00	211256194.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	136576413.00	130544219.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	92367864.00	96923849.38
210101	Үндсэн цалин	89100864.00	73020049.38
210102	Нэмэгдэл		16005800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3267000.00	7898000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10250100.00	11696764.00

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	10250100.00	7945515.00
210202	Тэтгэмжийн даатгал		993191.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		722553.00
210204	Ажилгүйдлийн даатгал		182837.00
210205	Эрүүл мэндийн даатгал		1852668.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1185000.00	0.00
210304	Байрны түрээс	1185000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	6839400.00	9374481.00
210401	Бичиг хэрэг	2221800.00	3726700.00
210402	Тээвэр, шатахуун	3651600.00	4531800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	966000.00	1085981.00
210404	Ном, хэвлэл		30000.00
2105	Нормативт зардал	300000.00	0.00
210502	Хоол, хүнс	300000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11088200.00	1660000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	465000.00	
210602	Тавилга	9571500.00	
210604	Урсгал засвар	1051700.00	1660000.00
2107	Томилолт, зочны зардал	4566800.00	4109500.00
210702	Дотоод албан томилолт	4566800.00	4109500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4324731.00	5779625.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3831251.00	5346200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80000.00	158400.00
210803	Даатгалын үйлчилгээ	262000.00	113005.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141480.00	140020.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10000.00	22000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5654318.00	1000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4654318.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1000000.00	1000000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	142002694.00	80711974.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	8514114.00	2694804.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2889114.00	2694804.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5625000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3687.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3687.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	133484893.00	78017090.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	133484893.00	78017090.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	80.62
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		80.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	339900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	339900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	339900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	339900.00
222001	Тоног төхөөрөмж		339900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-339900.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	8,050,128,107.14	0.00	8,050,128,107.14
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	8,050,128,107.14	0.00	8,050,128,107.14
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		5,099,924,090.48			5,099,924,090.48
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-1,719,833,475.50		-1,719,833,475.50
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	5,099,924,090.48	6,330,294,631.64	0.00	11,430,218,722.12

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	142205100.00	142201413.00	132245000.00	130884119.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	142205100.00	142201413.00	132245000.00	130884119.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	136580100.00	136576413.00	132245000.00	130884119.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	92370900.00	92367864.00	97606900.00	96923849.38
210101	Үндсэн цалин	89103900.00	89100864.00	73615100.00	73020049.38
210102	Нэмэгдэл	0.00	0.00	16005800.00	16005800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3267000.00	3267000.00	7986000.00	7898000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10250100.00	10250100.00	12097400.00	11696764.00
210201	Тэтгэврийн даатгал	10250100.00	10250100.00	8182800.00	7945515.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00	978700.00	993191.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00	782900.00	722553.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00	195700.00	182837.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00	1957300.00	1852668.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1185000.00	1185000.00	0.00	0.00
210304	Байрны түрээс	1185000.00	1185000.00		
2104	Хангамж, бараа материалын зардал	6839400.00	6839400.00	9391800.00	9374481.00
210401	Бичиг хэрэг	2221800.00	2221800.00	3420000.00	3419851.00
210402	Тээвэр, шатахуун	3651600.00	3651600.00	4531800.00	4531800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	966000.00	966000.00	1440000.00	1422830.00

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	300000.00	300000.00	0.00	0.00
210502	Хоол, хүнс	300000.00	300000.00		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11088400.00	11088200.00	2000000.00	1999900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	465000.00	465000.00	0.00	0.00
210602	Тавилга	9571500.00	9571500.00	0.00	0.00
210604	Урсгал засвар	1051900.00	1051700.00	2000000.00	1999900.00
2107	Томилолт, зочны зардал	4566800.00	4566800.00	4150000.00	4109500.00
210702	Дотоод албан томилолт	4566800.00	4566800.00	4150000.00	4109500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4325000.00	4324731.00	5998900.00	5779625.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3831500.00	3831251.00	5300000.00	5229720.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80000.00	80000.00	158400.00	158400.00
210803	Даатгалын үйлчилгээ	262000.00	262000.00	262000.00	113005.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141500.00	141480.00	256500.00	256500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10000.00	10000.00	22000.00	22000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5654500.00	5654318.00	1000000.00	1000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4654500.00	4654318.00		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1000000.00	1000000.00	1000000.00	1000000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5625000.00	5625000.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5625000.00	5625000.00	0.00	0.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5625000.0	5625000.0	0.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	142205100.00	142205100.00	132245000.00	130884119.38
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	121035100.00	121035100.00	107245000.00	107245400.00
132001	Орон нутгийн төсвөөс	121035100.0	121035100.0	107245000.00	107245400.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	21170000.00	21170000.00	25000000.00	23638719.38
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20552240.0	20552240.0	25000000.00	23638719.38
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	617760.0	617760.0	0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10.00	10.00	10.00	10.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00	7.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	2.00	2.00